

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх” төслийн нэгж нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“GO-CS-7-Дулааны шугамын огтолгооны төхөөрөмж нийлүүлэх”** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үнийн санал авах урилга нь 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр “UNDB” дээр нийтэлсэн Төслийн Худалдан авах ажиллагааны Ерөнхий мэдэгдлийн дагуу зарлагдаж байна.

Үнийн санал авах урилга нь Дэлхийн Банкны Зээлдэгч нарт зориулсан худалдан авах ажиллагааны журам, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА: Бараа, Ажил, Зөвлөх ба Зөвлөхийн бус үйлчилгээ (2016 оны 7 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сард шинэчилсэн)-ний дагуу үнийн санал авах аргаар явуулах бөгөөд худалдан авах ажиллагааны журамд тодорхойлсон эрх бүхий бүх тендерт оролцогчдод нээлттэй байна. Мөн Дэлхийн Банкны ашиг сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлогыг уг журмын 3.14. Сонирхлын зөрчил хэсгийг мөрдөнө үү.

Оролцохыг сонирхсон этгээд нь үнийн санал авах бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Оролцогч нь үнийн саналаа 2 хувь бэлтгэж ирүүлэх ба хуудас бүрийг дугаарлан материал тус бүрийг битүүмжлэн доорх хаягаар ирүүлнэ. Үнийн санал авах материалыг цахимаар хүлээн авахгүй. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. **“Үгүй”**

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2019, 2020, 2021 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх.
- Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний дагуу гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээллийг ирүүлэх жилийн тоо: Сүүлийн гурван жил (2019, 2020, 2021 он)
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Шаардлагагүй

Оролцохыг сонирхсон этгээд нь erbolat050411@gmail.com цахим хаягаар албан хүсэлт гаргаж дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2022 оны 6 дугаар сарын 20-ны 11:30 цагт нээнэ.

Хаяг: Эрчим хүчний яам, 3 дугаар давхар, Хурлын танхим Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Улаанбаатар хот, Монгол улс

Утасны дугаар: (976)-77006589, 88080060